

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 8-р сарын 11 өдөр

Улаанбаатар хо

“Блюскай секьюритиз ҮЦК” ХК – ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 8-р сарын 11 өдөр 09 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 3-р хороо, Жуулчны гудамж, Монгол Тайваны төвийн 2-р давхарт 207 тоот өрөөнд эхлэв.

Хуралд 4 гишүүн биеэр оролцсон болно. Хурлыг хурлын дарга, Гүйцэтгэх захирал У.Анар нээв.

Хурлын дарга У.Анар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөх зах зээлийн нөхцөл байдал, харилцагчдын эрэлт хэрэгцээг судалсны үндсэн дээр компани нь үйл ажиллагааныхаа чиглэлд Андеррайтерийн үйл ажиллагааг нэмж авах шаардлагатай гэж үзсэн тул энэхүү ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж байна. Компанийн хаяг нь компанийн дүрэмд агуулагддаг мэдээлэл тул дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах гэдэг асуудлын хүрээнд хэлэлцэнэ. Компанийн албан ёсны хаягийг Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жуулчны гудамж, Делта төв, 5 давхарт, 502 тоот болгон өөрчлөх саналтай байна. Хуучин оффис нь түрээсийн талбайн м2 нь бодит биш 3 м2-р илүү төлбөр авч байгааг мэдсэн, тохиролцож чадаагүй тул гэрээгээ цуцалхаас өөр аргагүйд хүрлээ.

Мөн ганц брокероор ажиллаад үйл ажиллагааныхаа зардалыг ч төлж чадахгүй байгаа тул андеррайтерийн тусгай зөвшөөрөл авах нь зүйтэй гэж үзсэн. Компаниуд нээлттэй хувьцаат компани болох сонирхол их байна.

Хувьцаа эзэмшигчид: Зөвшөөрч байна. Андеррайтерийн үйл ажиллагаа шинээр эрхлэхтэй холбоотойгоор холбогдох дүрэм, журам батлах эрхийг компанийн ТУЗ-д олгоё.

ТУЗ-ийн дарга Г.Оюунболд: Андеррайтерийн тусгай зөвшөөрлийг авахын тулд нэмэлт хувьцаа гаргаж хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх шаардлагатай болсон.

Хувьцаа эзэмшигч Г.Намхайдорж: Андеррайтерийн тусгай зөвшөөрөл бүхий компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1.5 тэрбум төгрөг байхыг шаардаж байгаа. Бусад тусгай зөвшөөрлүүд ч бас хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээтэй байдаг тул 2 тэрбум төгрөг хүртэл нэмэлт хувьцаа гаргах гэдэг байдлаар шийдэх нь зөв байх. Үнэлгээний компанийн үнэлгээ болон андеррайтерийн компанийн дүгнэлтээр тоо ширхэг тодорхой болох байх.

Хувьцаа эзэмшигчид: Зөвшөөрч байна.

Г.Оюунболд: хувьцаа эзэмшигч та бүхэнд компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг танилцуулж байна. Асуух зүйл байвал хэлээрэй.

Хувьцаа эзэмшигчид: Зөвшөөрч байна. Асуух зүйл алга.

ТУЗ-ийн дарга, хувьцаа эзэмшигч Г.Оюунболд: Компани өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, Санхүүгийн зохицуулах хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, эрхээ сэргээлгэх шаардлагын улмаас их хэмжээний хэлцэл хийж таарах байх. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус энэхүү хурлаараа компанийн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт оруулах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэхээр хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан уг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон боловч эсрэг саналтай байсан эсхүл уг хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчид Компаний тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэдгийг мэдэгдэх хэрэгтэй байх.

Хувьцаа эзэмшигчид: Шаардах эрх хэрэгжүүлэх нь зөв.

Ийнхүү ээлжит бус хурал 10 цаг 40 минутад дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  Дөлгөөн. /

ХУРЛЫН ДАРГА:  У.Анар

